



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

198 /198/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.12.10

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

## БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЖИЛИЙН АЖЛАА ДҮГНЭЛЭЭ

Өчигдөр Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжүүдийн 2021 оны нэгдсэн тайлангийн "Батлан хамгаалахын нэгдмэл хяналт" сэдэвт хурал явагдлаа.

Тус оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцаж, нэгдсэн дүн гаргах, цаашид хэрэгжүүлэх хяналт шалгалтын бодлого чиглэлийг тодорхойлох зорилготой тус хуралд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Ерөнхий хянан шалгагч хурандаа Ж.Болдбаатар, түүний ажлын алба болон Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжүүд, ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэс, Авто техникийн хяналтын албаны дарга, бие бүрэлдэхүүн оролцлоо.

Хурлыг нээж хурандаа Ж.Болдбаатар "Оны эхэнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагуудад энэ салбарт хяналт шалгалтыг хэрхэн зохион байгуулах талаар танилцуулсан. Батлан хамгаалах салбарын үйл ажиллагааг илүү төгөлдөржүүлэх, зөрчил дутагдлыг арилгах талаар тодорхой бодлого гаргасан. Батлан хамгаалахын хяналт шалгалтын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, нэгдмэл хяналтыг бий болгохоор зорьж нэг жилийн хугацаанд ажиллалаа. Өнөөдөр үр дүнг нь хэлэлцэж, цаашдын зорилго чиглэлээ тодорхойлох болно" гэв.

Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын албаны 2021 оны үйл ажиллагааны тайланг ажлын албаны дарга хурандаа Т.Мөнхбаяр танилцууллаа. Ингэхдээ

Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалт, үнэлгээний ажлын бодлого, чиглэлийг тодорхойлж, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын үнэлгээний нэгжүүдийг нэгдсэн удирдамж, мэргэжил, арга зүйгээр хангах, ажлын уялдаа холбоог зохицуулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах үйл ажиллагааг үндсэн зорилгоо болгон хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн БХЯ-ны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланг тус газрын дарга хурандаа Б.Эрхэмбаяр танилцуулсан юм. Үүний дараа Зэвсэгт хүчний Хяналт-Шинжилгээ, үнэлгээний газрын дарга хурандаа Ж.Өсөхбаяр 2021 оны үйл ажиллагааныхаа тайланг танилцууллаа. Түүнчлэн ЗХЖШ-ын ЭМХ-ийн дарга хурандаа Т.Сүхбаатар Зэвсэгт хүчний хэмжээнд ковидын эсрэг дархлаажуулалтын талаар авч хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулж, мэдээлэл өгөв.

Хурлын үеэр дэд сайд Б.Баярмагнай "Хяналт, шалгалт дотоод аудитын үйл ажиллагаа нь аль ч салбар, байгууллагын хувьд удирдлагын нүд, чих нь байж, гаргасан бодлого шийдвэр, үйл ажиллагааныхаа буруу зөвийг ялган тунгаах, цаашид хэрхэн засаж залруулахад дэмжлэг үзүүлэх, байгууллагыг учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд гол үүрэгтэй байдаг. Энэхүү хариуцлагатай үүргээ тасралтгүй, үр дүнтэй явуулахын төлөө Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжүүдийн



бие бүрэлдэхүүн сэтгэл, зүтгэл гарган ажилласан нь ч энэхүү нэгдсэн тайлангийн дүнгээс тодорхой харагдаж байна. Мөн зөрчил, дутагдлууд ч багагүй байна. Тиймээс зөрчил, алдаа дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлд илүү анхаарч ажиллах ёстой. Олон ажил хийхдээ бус үр дүнтэй, өгөөжтэй ажил санаачилж хэрэгжүүлэх нь чухал. Батлан хамгаалах, Зэвсэгт

хүчний удирдлагууд бүх талаар дэмжихэд бэлэн" гэв. Тэрбээр төгсгөлд нь хуралд оролцсон бие бүрэлдэхүүнд хандан төсөв, санхүүгийн сахилга хариуцлагыг өндөржүүлэх, цэргийн алба, цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хяналт шалгалтыг үр дүнтэй болгох талаар үүрэг чиглэл өгч, ажлын амжилт хүссэн юм.

## ХЗЦК ГАДААД ХЭЛНИЙ ТАНХИМТАЙ БОЛЖ



Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлалд АНУ-ын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан англи хэлний танхимын нээлтийн арга хэмжээ өнөөдөр зохион байгуулагдлаа. Эл арга хэмжээнд ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч хошууч генерал Б.Амгаланбаатар, ЗХЖШ-ын Гадаад хэлний сургалтын төвийн дарга дэд хурандаа Ч.Тунгалаг, АНУ-ын Элчин

сайдын яамны орлогч дарга Грегори Мэе, АНУ-ын ЭСЯ-ны Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Филип Луу болон албаны бусад хүмүүс оролцлоо.

Монгол Улс, АНУ-ын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, тэр дундаа хоёр улсын цэрэг, техникийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд нэлээд өсөж байгаа билээ. Үүний нэг жишээ нь АНУ-ын болон Монгол Улсын Зэвсэгт хүчний ХЗЦК-уудын

зөвлөлдөх уулзалтаар хэлэлцсэн бие бүрэлдэхүүний англи хэлний түвшнийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд АНУ-ын талаас ХЗЦК-д хоёр нэгж англи хэлний танхимын тоног төхөөрөмжийг энэ оны 4 дүгээр сард хүлээлгэн өгснөөр илэрхийлэгдэж байна.

Энэхүү иж бүрэн тоног төхөөрөмж бүхий хоёр танхимын нэгийг Хуурай замын цэргийн командлалд, нөгөөг нь Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид байгуулжээ. Түүнчлэн ХЗЦК нь танхимуудын сургалтын материаллаг баазыг бүрдүүлэх, багш нарыг томилох зэрэг зохион байгуулалтын ажлуудыг шат дараатай авч хэрэгжүүлээд байгаа бөгөөд суралцах бүрэлдэхүүний судалгааг гарган сургалтыг явуулахад бэлэн болжээ.

Нэг танхимд 20 цэргийн алба хаагч суралцах боломжтой бөгөөд 2022 он гараад эхний 40 суралцагч ХЗЦК болон Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн Гадаад хэлний сургалтын танхимдаа суралцаж эхлэх юм. ХЗЦК-ын Гадаад хэлний сургалтын төвийн англи хэлний багшаар ахлах

ахлагч Ч.Батболд ажиллах бол Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид ахлах ахлагч Н.Дэлгэрхүү ажиллах юм. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч хошууч генерал Б.Амгаланбаатар нээлтийн ажиллагааны үеэр "Цэргийн алба хаагчийн үүргээ амжилттай гүйцэтгэх нэг үндэс нь зэвсэг техникийн бэлэн байдлаас гадна цэргийн сургалт гэж хэлж болно. Тиймээс энэхүү гадаад хэлний сургалтын танхим нь чухал бөгөөд цаашид офицер, ахлагч нарыг АНУ-ын төрөл бүрийн шаталсан дамжаануудад хамруулах, хамтарсан дадлага сургуулийг явуулах, дэлхийн бусад улсын цэргийн алба хаагчидтай мөр зэрэгцэн энхийн үйлсэд үүрэг гүйцэтгэхэд НҮБ-ын үндсэн зургаан хэлийн нэг болох англи хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшихэд эдгээр танхим чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Энэхүү ажлыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэн ажилласан БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, АНУ-ын ЭСЯ-ны бүрэлдэхүүнд талархлаа илэрхийлээд та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье" гэлээ.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 374.040 +139	ВАКЦИНЖУУЛАЛТ 2,153,968 +560	НАС БАРСАН 1,947 +3
----------------------------------	---------------------------------	------------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6621 +111	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 88	ЭДГЭРСЭН 6406
------------------------------	---------------------------	------------------

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 268,068,447
Эдгэрсэн Нийт: 241,266,386
Нас барсан Нийт: 5,294,421

1921 он.  
1921 он. АЗГ-ын 28 дугаар хурлын тогтоолоор монгол цэргийн цахилгаан мэдээний мэргэжилтэн бэлтгэх цэргийн сургууль байгуулжээ.

2001 он.  
Зэвсэгт хүчний Ерөнхий штаб Энхийг дэмжих ажиллагааны хэлтэс байгуулагдсан.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-26

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

## ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,855.0
EUR	3,182.0	3,253.0
CNY	446.00	450.50
RUB	37.80	39.80
JPY	24.75	25.39
KRW	2.34	2.47

## ЗУРХАЙ

2021.12.10 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 07/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

### Үс засуулбал:

Өнгө зүс сайжирна  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.30-16.59  
БАРИЛДЛАГА:  
Үл зохилдох  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Нэр өнгө  
Суудал:  
Хий

Энэ өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба гараагийг тахиж, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, уул овоо тахирад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өнгө зүс сайжирна.

Үс засуулбал ӨНГӨ ЗҮС сайжирна

цаг үе, үйл явдал

## ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал болон АНУ-ын Номхон далайн Агаарын хүчнүүд хоорондын зөвлөлдөх уулзалтыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал анх удаа бие даан эх орондоо амжилттай зохион байгуулж явууллаа.

Зөвлөлдөх уулзалтад Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр, хурандаа Б.Энхзоргол, АНУ-ын Номхон далайн агаарын хүчний командлагчийн Үндэсний гвардын орлогч дарга хошууч генерал Дэвид Бурги болон Монгол Улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Агаарын цэргийн командлал, АНУ-ын Номхон далайн агаарын хүчний штаб, АНУ-ын Энэтхэг-Номхон далайн цэргийн командлал, Аляска мужийн Агаарын хүчний үндэсний гварди, шуурхай харуу үзүүлэх 36 дугаар хороо, АНУ-ын Агаарын цэргийн

төв штабын Олон улсын харилцааны газар, Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамны Батлан хамгаалахын хамтын ажиллагааны албанаас тус тус төлөөлөгчид оролцлоо. Мөн Аляскийн нисэх хүчний үндэсний гвардын командлагч бригадын генерал Трэси Смит цахимаар оролцсон юм.

Зөвлөлдөх уулзалтыг Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр, АНУ-ын Номхон далайн агаарын хүчний командлагчийн Үндэсний гвардын орлогч дарга хошууч генерал Дэвид Бурги нар удирдан харилцан айлчлал, хамтын ажиллагаа, хамтарсан сургууль, дадлага, ар талын хангалт, эрүүл мэнд зэрэг сэдвийн хүрээнд явууллаа.

Энэхүү зөвлөлдөх уулзалтын үр дүнд хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа улам батжиж, Агаарын цэргийн офицер, ахлагч

нарын хамруулах сургууль, дамжааны тоо, төрлийг нэгдүүлэхээр зөвшилцөлд хүрсэн ба Номхон далайн бүс нутагт явагддаг олон улсын хээрийн сургуулиудад оролцох Монгол Улсын статусыг нэмэгдүүлэх, иргэн цэргийн хосолмол зориулалттай нисэх буудлын үйл ажиллагааг ханган явуулахад шаардагдах техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зэрэг хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд түлхэц болсон гэж үзэж байна.

Зөвлөлдөх уулзалтад оролцсон АНУ-ын хүндэт зочид, төлөөлөгчдийг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Ганхуяг, ЗХЖШГ-ын эвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг нар хүлээн авч уулзан хоёр орны хамтын ажиллагааны талаар тэр дундаа Агаарын цэрэг хоорондын цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон юм.

## “БАЙР ЗҮЙН ОФИЦЕРУУД БЭЛТГЭГДЭН ГАРЛАА

### ҮБХИС


Батлан хамгаалахын сайдын тушаалаар ҮБХИС-ийн Цэргийн Нэгдсэн Дээд Сургуулийн Ерөнхий цэргийн тэнхимийг түшиглэн “Байр зүйн офицерын дамжаа”-ны сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү сургалтад Зэвсэгт хүчний 19 ангийн төлөөлөл болох 19 офицер

суралцаж амжилттай төгслөө. Уг сургалтад хамрагдсанаар Зэвсэгт хүчний анги, байгууллагад тайван болон байлдааны цагт байр зүйн хангалтыг төлөвлөх, зохион байгуулах, цэргийн байр зүйн зургийг захиалах, түгээх, бүртгэх ажиллагаанд суралцан дадлагашиж, чадварлаг боловсон хүчин болж

бэлтгэгдээд байна.

Ташрамд дурдахад, Цэргийн Нэгдсэн Дээд Сургуулийн Ерөнхий цэргийн тэнхимийн сонсогчдын бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, 029, 032 дугаар ангиудад удирдах ур чадварын дадлага гүйцэтгэж сурсан мэдлэг, ур чадвараа бататгасан байна.



## “ЗӨВ МАНЛАЙЛАЛ” УРАЛДААНД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА



## СОЁМБО РЕДАКЦ

Батлан хамгаалах салбарын  
хэвлэл мэдээллийн байгууллага

Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан NUTAG.MN вэб сайттай хамтран Зэвсэгт хүчний хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион байгуулах “Зөв манлайлал” уралдааны удирдамжийг хүргэе.

### Нэг. Уралдааны зорилго:

1. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг нийгэмд сурталчлах зорилго бүхий цахим хөгжүүлэлтийг идэвхжүүлэх, хандалтыг нэмэгдүүлэх замаар түүхт ой, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, анги, салбар, цэргийн алба, тэргүүний цэргийн алба хаагчдыг олон нийтэд сурталчлах;

2. Төр, хувийн хэвшлийн хэвлэл, мэдээллийн байгууллагын харилцаа, үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан үйл ажиллагаандаа дэмжлэг үзүүлэх;

3. Түүхт ой тохиож буй энэ жил хугацаат цэргийн алба хааж буй цэргийн алба хаагчдыг сурталчилж, тэдэнд түүхэн ойн ач холбогдлыг судлах сэдэл, тэмүүлгийг бий болгох, олон нийтэд Батлан хамгаалах салбарын түүхэн хөгжил, онцлох үйл явдлуудыг сурталчлан таниулах;

4. Шинэ үеийн төлөөлөл болсон залуусын бие хүний хөгжлийг дэмжих, хөгжүүлэх, тэдний дундаас илтгэх авьяас чадвартай, бусдадаа эергээр нөлөөлөх, зөв харилцаа хандлага, хүмүүжил төлөвшилтэй манлайлагч нарыг илрүүлэн гаргаж ирэх, тэдний авьяас, чадварыг нээж хөгжүүлэх, зөв, цэгцтэй сэтгэж, өөрийн үзэл бодлоо уран яруу илэрхийлэх арга зүйд сургах;

5. Цэргийн алба хаагчдад эх оронч үзэл, хүмүүжил, эх орноо батлан хамгаалах зоригийн чанар, итгэл үнэмшлийг төлөвшүүлэх болон хүмүүжлийн бусад үйл ажиллагаанд эдгээр зөв манлайлалтай, тэргүүний байлдагчдыг идэвхтэй татан оролцуулах замаар дайчдыг цэргийн албанд богино хугацаанд дасгах, цэргийн албыг бэхжүүлэх, албандаа хандах эерэг хандлагыг төлөвшүүлж, албаны ухамсрыг дээшлүүлэхэд нь эергээр нөлөөлөх тогтолцоог бий болгож хөгжүүлэх.

### Хоёр. Хамрах хүрээ:

Энэхүү уралдаанд Монгол Улсын өнцөг булан бүрд байрлаж буй Зэвсэгт хүчний бүх нэгтгэл, анги, салбарт цэргийн алба хааж байгаа цэргийн хугацаат албаны түрүүч, байлдагчид оролцоно.

### Гурав. Уралдааны журам, хугацаа, үе шат:

Тус уралдаан нь 3 үе шаттай явагдана.

Нэгдүгээр шат: Оролцогчид “Эх орон” сэдвийн хүрээнд өөрийн боловсруулж бэлтгэсэн илтгэлийн хүрээнд 3 минутын багтаамжтай бичлэг хийж, уг бичлэгийг Батлан хамгаалахын “Соёмбо” редакцын “Дуулга” студийн фэйсбүүк хуудасны чат буюу мессенжерээр 2021 оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлж, онлайн аар оролцоно. Уралдааныг шүүх шүүгчдийн комисс цахимаар хүлээн авсан бичлэгүүдийг үзэж шилдгийн шилдэг 10 илтгэгчийг шалгаруулна.

Хоёрдугаар шат: Нэгдүгээр шатнаас шалгарсан “Шилдэг 10 оролцогч”-дод зохион байгуулагчдын зүгээс хувийн дугаар олгон тухайн оролцогчийн бичлэгийг нэгтгэл, анги, салбарын Соёл хүмүүжлийн офицероор дамжуулан “Дуулга” студийн фэйсбүүк хуудсанд тодорхой хугацаагаар байршуулна. Цахим хуудсанд байршуулсан бичлэгээс хамгийн олон лайк, хуваалцах буюу share цуглуулж чадсан 5 бичлэгийг шалгаруулан гуравдугаар шатанд оролцуулна. Өөрөөр хэлбэл, энэ шатны шалгаруулалтыг зөвхөн үзэгчид хийх юм.

Гуравдугаар шат: Хоёрдугаар шатнаас шалгарсан “Шилдгийн шилдэг-5” оролцогчийг төгсгөлийн шатны шалгаруулалт шууд дамжуулалтаар үзэгчдэд хүрнэ. Шууд дамжуулалтын үеэр шүүгчдийн зүгээс Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 110 жилийн ой, Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэн ойттой холбоотой асуултууд бэлтгэсэн байх ба оролцогч асуултыг сугалж, сугалсан асуултад хариулна. Оролцогчдын асуултад зөв, оновчтой хариулсан байдалыг харгалзан шүүгчид 0-10 оноогоор дүгнэнэ. Оролцогч тус бүр асуултад хариулж дууссаны дараа шүүгчдийн өгсөн онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо авсан дарааллаар байр эзлүүлэн шагнаж, урамшуулна.

### Дөрөв. Уралдааны зохион байгуулалт:

Уралдааны төгсгөлийн шатны шалгаруулалт тусгай хөтөлбөрөөр ивээн тэтгэгч байгууллагын сонгосон ресторанд зохион байгуулагдаж, БХЯ, ЗХЖШ-ын удирдлагын бүрэлдэхүүн оролцох бөгөөд БХЯ, ЗХЖШ, ХЗЦК, Соёмбо редакц, ҮБХИС-ийн БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төв, Nutag.mn вэб сайтаас томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн шүүн явуулна. Уралдааны төгсгөлийн шатны шалгаруулалт, шагнал гардуулах арга хэмжээг Nutag.mn вэб сайт, “Дуулга” студийн цахим хуудсаар шууд дамжуулж, Nutag.mn вэб сайтын 21 аймаг дахь салбар, “Соёмбо” сонин болон цахим хуудас, “Соёмбо мэдээ” өдөр тутмын цахим сонин, МҮОНТ-ээр цацагдах “Эх орны төлөө” нэвтрүүлгийн булангаар тус тус улс орон даяар төдийгүй дэлхийн өнцөг булан бүрд сурч, ажиллаж, амьдарч байгаа, тэрчлэн халуун цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчдадаа хүргэн сурталчлах бөгөөд уралдааны оролцогчид хугацаат цэргийн алба хаах хугацаандаа социал хэрэгслээр өөрийгөө нээн харуулах, хөгжүүлэх, олны танил болж улмаар ажил олгогчдын анхааралд өртөж ажлын санал, урилга хүлээн авах, улмаар цэргийн албанаас бэлтгэлээр халагдсаны дараа шууд ажлын байртай болох зэрэг өргөн боломж, үүд хаалга нээгдэх юм.

### Шагнал, урамшил:

1 дүгээр байр нэг. “Өргөмжлөл”, дурсгалын зүйл, Nutag.mn вэб сайтын нэрэмжит бэлэг;  
2 дугаар байр нэг. “Өргөмжлөл”, дурсгалын зүйл, Nutag.mn вэб сайтын нэрэмжит бэлэг;  
3 дугаар байр нэг. “Өргөмжлөл”, дурсгалын зүйл, Nutag.mn вэбсайтын нэрэмжит бэлэг;  
Тусгай байр 2. “Өргөмжлөл”, дурсгалын зүйл, Nutag.mn вэб сайтын нэрэмжит бэлгээр тус тус шагнаж урамшуулна.

БАТЛАН ХАМГААЛАХЫН “СОЁМБО” РЕДАКЦ



Дарга, ерөнхий редактор, хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний  
Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



“Соёмбо” сонин  
“Дуулга” студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018

Цахим шуудан:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)